

ХЭЛЦ НЭГЖИЙН “ДОТООД ХЭЛБЭР”-ИЙН ТУХАЙ АСУУДАЛД

Л. Ганчимэг¹

Дотоод хэлбэр хэмээх ойлголтыг анхандаа дан үгэнд хамаатай асуудал болгон авч үздэг байжээ. Учир нь хэлний үндсэн нэгж нь үг гэж үздэг байсантай холбоотой байсан бололтой. Үгийн дотоод хэлбэрийн тухай XIX зууны үед В.Гумбольд, Х. Штейнтель нар: “бодол санааг авиатай холбон үгэнд биежүүлэх арга” (Звегинцев, 1957, 186-214)² хэмээн тодорхойлж байжээ.

Харин Оросын хэлшинжлэлд дотоод хэлбэр гэдэг ойлголтыг анхлан дэвшүүлсэн хүн бол А.А. Потебня гэдэг. Тэрээр 1913 онд хэвлүүлсэн “Мысль и язык” гэдэг бүтээлдээ үгийн дотоод хэлбэр гэдэг нь “Үгийн гарлыг мэдрүүлэх хамгийн ойр утга буюу агуулгыг илэрхийлж байгаа аргыг хэлнэ.” (1913:146)³ гэжээ. Энэ санаагаа дэлгэрүүлэн жишээлэн тайлбарласныг үзвэл: Аливаа үгэнд авиа, утгын тэмдэг буюу төсөөлөл, утга гэсэн гурван үндсэн махбод байна. Утгын тэмдэг буюу төсөөлөл гэдэг бол тухайн харгалзах юмын шинжийн нэр бөгөөд чухам үүнийг ашиглаж гэмээнэ нэг юмыг нөгөө юмтай адилтгаж зүйрлэх боломжтой болно гэх буюу “утгын тэмдэг гэдэг бол ухаан бодлоороо адилтган зүйрлэж болох хоёр нэгжийн аль алинд нь байдаг ерөнхий (нийтлэг) зүйл буюу зүйрлэлийн үндэс болсон зүйл нь юм” (Потебня, 1958:17)⁴ гээд үүнийхээ үлгэр болгож дараах жишээ авсан байна. Үүнд, гэрлийн шилний дугуй бөөрөнхий бүрхэвч халхавчийг бяцхан хүүхэд “амтат гуа” (арбуз) хэмээн нэрлэдгийг дурдаад урьд нь мэдэхгүй (танил биш) байсан, шинэ юмыг хүүхэд таньж мэдэхдээ урьд нь мэддэг байсан “амтат гуа”-тай “абажур”-ыг хэлбэр дүрс, төсөөр нь харьцуулах аргыг хэрэглэж байгаа учраас ийн нэрлэх болсон. Ийнхүү шинэ үгийн утганд мэддэг үгийнх нь утгаас “бөмбөлөг хэлбэрт” гэсэн шиг зөвхөн ганцхан л ялгаруулах шинж (дифференциальный признак) шилжин орсон байдаг. Үүнийг утгын тэмдэг буюу төсөөлөл гэж нэрлэнэ гэжээ. Үгийн тэмдэглиг шинж нь түүнд харгалзах дүр буюу ухагдахууныг орлуулан солих зайлшгүй нөхцөл болдог бөгөөд шинэ юм үзэгдэлтэй тулгарч, түүнийг таньж мэдрэх гэсэн бодол санаа хөвөрч байх үед үгийн энэхүү тэмдэг нь таньдаг, таньдаггүй, мэддэг байсан, мэдэхгүй байгаа хоёр зүйлийг төлөөлөх (презставитель) үүрэгтэй бөгөөд ингэхлээр түүнийг төсөөлөл (представление) хэмээн нэрлэмээр юм (мөн тэнд. х.18) гэжээ.

А.А.Потебня-гийн хэрэглэсэн “представитель, представление” гэдэг томъёолол нь танин мэдэхүйн үйл ажиллагааны үе шатны үүднээс “төсөөлөл” ч гэж ойлгож болох,

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Звегинцев В.А. Семасиология. М. 1957

³ Потебня А.А. Мысль и язык. Харьков. 1913

⁴ Потебня А.А. Из записок по русской грамматике. Т. 1-2. М., 1958

“төлөөлөл” ч гэж ухаарч болох зүйл хэмээн санагддаг. Учир нь тэс өөр хоёр зүйлийг төслиг шинжээр нь өөр хооронд нь харьцуулж, нэгийг нь нөгөөгийн орлуулга болгон нэрлэж байгаа үзэгдэл гэж болно. А.А.Потебня-гаас өмнөхөн жишээлсэн “чийдэнгийн бүрхүүл”, “амтат гуа” хоёр хэлбэрээрээ л төслиг болохоос биш тэс өөр хоёр юм байгаа.

Үүнээс хагас зуун жилийн дараа 1960-70-аад оны үед Америкийн гүн ухаантан Макс Блейк (Max Black) Метафор үүсэх үндсэн арга нь “орлуулга буюу төлөөлөл” гэж үзээд тусгай онол боловсруулсан байдаг нь цаад утгаараа Потебня-гийн санаатай нийтлэг шинжтэй байна.

Гадаад ертөнцийн юм, үзэгдлийн хэд хэдэн шинжийг агуулж байгаа (үгийн) нэг л утга нь хэд хэдэн өөр үг үүсэх эх сурвалж болдог нь хэлний үг бүтэх ёсоор илэрч буй ухагдахуун, мэдлэг, ухаарал шатлан тэлэх зүй тогтол юм. Гэхдээ нэг үгийн утгыг үүсгэхэд чухал учир холбогдолтой байсан нэгэн шинж, уг үгийг хэрэглэх явцад, нэг үеийнхэнд мэдрэгдэхгүй болж бүдгэрдэг нь бас нэг ерийн үзэгдэл ажээ. Жишээлбэл, “гол гаргах” гэдэг хэллэг анх үүссэн шалтгааныг 1970-аад онд Д.Мягмарын зохиосон “Үер” туужаас сэдэвлэсэн киноны нэг үйл явдалтай холбож үзэхээс өөрөөр шууд тайлбарлах аргагүй болтолоо үүтгэл утга нь бүдгэрсэн байна.

Хэлцсудлалын талаар оросын хэлшинжлэлд бие даасан үзэл баримтлал үүсгэн хөгжүүлсэн В.В. Виноградов үгийн дотоод хэлбэр бол үндэстнийг соёлын үүднээс товойлгон тодорхойлж болох тийм дүр төдийгүй, түүний тухай үнэлэмжийн илэрхийлэл болохуйц бодит ертөнцийн тухай тайлбар юм (Виноградов 1972:20-21)⁵ гэсэн нь хэлц нэгжийн утгыг тайлахад тухайн хэлийг төрөлх хэлээ болгосон үндэстний бүтээн уламжилж ирсэн эдийн ба оюуны соёлын зүйл хэлээрээ яаж утгажин илэрдэгийг зайлшгүй анхаарч үзэх ёстой гэсэн чухал санааны утгал байсан гэж үзүүштэй байна. Энэ санааг XX зууны эцэст оросын хэлц судлалын бас нэг шинэ дэг үүсгэсэн В.Н.Телия өргөжүүлэн үндэстний соёлын (“культурно-национальная”) онцлогийг хэлц нэгжийн нэрлэх (номинатив) үүрэгтэй уялдуулж тайлбарлах учиртайг нотолсон нь онол аргазүйн үндсэн чиг баримжаа болсныг энд зориуд тэмдэглэе.

В.А. Звегинцев “Семасиология” гэдэг бүтээлдээ “үгийн дотоод хэлбэр гэдэг нь шинэ үгийг бүтээдэг хэлний шалтгаант хамаарал (языковая мотивированность) юм. Энэ үзэгдэл нь утгасудлалд (семасиология) хамаатай бус, харин нэрсудлалд (онамасиология) хамаатай үзэгдэл юм” (1957: 196)⁶ гээд угаасаа хэлэндээ байсан үгсээс шинэ үг бүтээх, шинэ утга бүтээх хоёр үзэгдлийг ялгах хэрэгтэй. Үүсвэр (производящее) үгийнхээ утгаас үүсгэвэр (производное) үг нь утга санааны хамааралтай байгаа нь эхэн үедээ илэрхий мэдрэгдэж байснаа цаашдаа энэ хамаарал нь сулран суларсаар бүр мартагдах нь ч бий гэж тэмдэглэсэн байна. Үүнийг бид Б. Ринчен “Монгол бичгийн хэлний зүй” (Хэлбэр судлал) бүтээлдээ: орчин цагийн монгол хэлний “эхнэр” гэдэг үг нь гаралзүйн хувьд, эцгийн эрхэт ёс буюу нэг эр олон эхнэр авдаг (полигами) үед төрүүлсэн эхээ “эх” гээд, түүнээс бусад, эцгийнх нь авааль эмсийг “эх+нар” гэж байснаас энэ хэлбэр үүсч, ганц аваальтай болсон моногами ёсны үед энэ үг анхны тэрхүү утга санааны хамаарлаа алдсаныг гэрчилж байгаа хэмээн тэмдэглэсэн тэр зүйл В.А.Звегинцевийн дээр өгүүлсэн санааны агуулгатай холбогдох зүйл гэж үзэж болох юм.

⁵ Виноградов В.В. Русский язык: Грамматическое учение о слове. М., 1972.

⁶ Звегинцев В.А. Семасиология. М. 1957

В.А.Звегинцев шинэ үг бүтэх, шинэ утга бүтэх үзэгдлийг ялган ойлгох хэрэгтэйг тэмдэглээд үгийн дотоод хэлбэр нь семасиологи-д биш, онамасиологи-д хамаатай гэсэн нь нэлээд өвөрмөц санал бололтой. Үүнийг В.Н. Телия-гийн 1980-90-ээд онд хийсэн судалгаа онол-аргазүйн дэгийн гол зарчимтай харьцуулан үзэж болно. Тэрээр хэлц нэгж, ялангуяа өвөрмөц хэллэг нь бүтэц- утгазүй (структурно-семантический) үзэгдэлд бүхэлдээ хамаарахаасаа илүү шууд бус нэрлэлт (непрямая номинация) зэрэг шинэ нэрлэлт үүсэх харилцахуйн хэрэгцээнд хамаатай үзэгдэл болно (1996)⁷ гэсэн нь хэлц нэгжийг шинэ парадигма-д авч үзэх ёстой гэсэн санааны мөн чанар гэж хэлж болно.

Өөрөөр хэлбэл В.Н. Телия-гийн тэмдэглэснээр Оросын хэлц судлалын талаарх В.А.Виноградов, түүний тэр үеийн шавь нарын судалгааг, мөн Ш. Балли-гийн “франц хэлний найруулга зүй” номондоо дэвшүүлсэн хэлний тогтвортой нэгж, түүний бүтэцзүй, утга зүйн онцлогийн тухай судалгаанууд нь бүхэлдээ хэлц нэгжийн сонгодог үед хамаарна гэсэн нь хэлц нэгжийн судалгааг үүсэн өрнөсөн цаг үе, тэр болгондоо баримталж байсан онол, аргазүйн шинжээр нь зааглан үечлэх боломжтой байна. Хэрэв ингэж үзвэл хэлний тогтвортой нэгжийн судалгаа нь

- 1950-1960-аад он хүртэлх буюу сонгодог үе

- 1970-аад оноос хойшхи буюу шинэ үе гэж болзмолоор ангилан хэлэлцэж болох юм.

Энэхүү болзмол ангилал нь “Дотоод хэлбэр”-ийн тухай онол, сургаалд бас нэгэн адил хамаатай байх шиг байна.

Монгол хэлний хэлц нэгжийн судалгааг бүхэлд нь ажиглавал, эхний үе нь мөн л Оросын хэлшинжлэлч нарын хэлц нэгжийн судалгааны “сонгодог үе”-ийн аргазүйг баримталсан байдалтай, харин В.Н. Телия, В.М. Мокиенко, А.М.Мелерович нарын хэлний соёл судлал, угсаатны хэлшинжлэлийн үүднээс судлах дэг сургуулийн үзэл баримтлал 1990-ээд оноос манай улсын хэлц судлалд эхлэл төдий байна гэж багцаалан хэлж болно.

Харин Ю.С.Маслов 1977 онд хэвлүүлсэн “Хэлшинжлэлийн удиртгал” бүтээлдээ үгийн дотоод хэлбэрийн тухай өмнө гарсан санал онолыг нэгтгэн өгүүлэхдээ “Мотивировка” гэдэг нэр томъёо хэрэглэсэн байна⁸. Мотивировка буюу шалтгаант үүтгэл гэдэг нь тухайн үгийн авианы дүр төрх буюу нийлц нь тухайн харгалзах утгыг үүсгэх шалтгаан болж үгэндээ биежсэнийг хэлэлцэгч этгээд ухамсарлаж байгаа “үндэслэл”-ийг хэлнэ (Маслов. 1977:160) гээд ийн шалтгаанцсан шинжийг үгийн утга шилжих үзэгдэл болон нэг үгээс дам үүссэн үгсийн бүтэц, агуулгаас ажиглаж болно. Ийм шалтгаанцал байхгүйгээр үг бүтэх ч үгүй, үгийн утга шилжих ч үгүй юм. Шилжмэл утга нь түүнтэй зэрэгцэн орших шууд утгаар шалтгаанцан үүтгэгдэх бол, үүсмэл үг нь түүнийг үүсгэсэн (үүсгэвэр) үгтэйгээ шалтгаанцсан хамааралтай байна. Гэвч энэхүү шалтгаанцмал үүтгэлийг үгийн шууд утгаас ялган ойлгох нь чухал.

Ингээд шалтгаанцмал үүтгэл бол Ю.С. Масловынхоор үгийн агуулга гэдэг нь утганд зайлшгүй байх бүрэлдүүлбэр биш бөгөөд тухайн үгийн, үгийн сангийн утгын багцалмал цөм (концептуальное ядро)-тэй холбогдсон бүрэлдүүлбэр бөгөөд эсвэл

⁷ Телия В.Н. Русская фразеология. Семантический, прагматический и лингвокультурологические аспекты. М., 1996. бүтээл бүхэлдээ хэлц судлалын шинэ дэгийн агуулга, аргазүйг орос, слав хэлц нэгжийн жишээ баримтаар нотлон үзүүлэхэд чиглэсэн байна.

⁸ Маслов Ю.С. Введение в языкознание. М., 1977

^{*} Мотивировка гэдэг нэр томъёог зөвхөн утгачилах үүднээс ийн “шалтгаант үүтгэл” хэмээн болзмолоор нэрлэснийг тэмдэглэе. Зарим тохиолдолд “шалтгаанцал” гэж нэрлэсэн ч болох юм.

сэтгэл хөдлөл ч юм уу, үгүй бол бусад хамсмал утгас (коннотация)-тай холбоотой илрэл байж болно (Мөн тэнд 138 дахь тал) гэж тэмдэглэсэн байна.

Монгол хэлний “чулуу-да-х” гэдэг үгтэй адил бүтцээр үүссэн “ташуур- да-х” гэдэг үгийг “ташуураар (ямар нэгэн юмыг) цохих” гэсэн утгатай, үүнтэй адилаар “сүх-дэ-х” гэвэл сүхээр цохих, улмаар хагалах /бутлах, бяцлах/ гэсэн утгатай болдог шиг чулуу-да-х гэхлээр ямар нэг юмыг чулуугаар цохих, эсвэл ямар нэг юм руу чиглүүлэн түүнийг онох зорилгоор чулуу хаях, шидэх гэсэн утгатай гэх мэтээр үүсмэл, үүсгэвэр утгын шалтгаацлын шууд ойлгогдох хэлбэр, агуулгыг тодорхойлж болох юм. Гэтэл “гутлаар чулууудах”, “аягаар чулууудах”, “үзэг харандаагаар чулууудах” гэх мэт олон жишээнээс илэрхийлэх утгы нь ажиглавал “гутал/аяга, үзэг, харандааг чулуугаар шидэх/хаяхтай адилаар чиглүүлэн шидсэн/хаясан гэсэн утга санааг илэрхийлдэг. Энэ бол адилтгасан, зүйрлэсэн утга буюу метафорич утга илэрч байгааг мэдэхэд төвөггүй байна.

Ийм үзэгдлийн үгийн дотоод утга нь уг үгийнхээ агуулгад зайлшгүй байх бүрэлдүүлбэр биш, харин “сэтгэл хөдлөл ч юм уу, эсвэл өөр зарим хамсмал утгыг илэрхийлэх, үгийн сангийн багцалмал цөмтэй холбогдмол утга байх юм хэмээн Ю.С.Маслов-оос бид өмнө ишилсэн зүйлтэй энэ жишээ тохирох үзэгдэл хэмээн санана.

Өөрөөр хэлбэл адгуусан амьтан, мал харыг хөөж туух ч юм уу, эсвэл агнаж хомроглох зорилгоор эртний хүмүүсийн (тухайлбал, монгол хүний) хэрэглэдэг түгээмэл зэвсэг нь чулуун зэвсгийн үеэс угшилтай даруй чулуу байсан болохоор “чулуу-да-х” хэмээх нийлэг бүтцийн анхдагч утга нь “чулуугаар шидэх/хаях, эсвэл “чулуу(г) шидэх/хаях гэсэн задлаг хэлбэртэйгээ дүйх бөгөөд “гутал/аяга/үзэг харандаа чулууудах” гэдэгт илэрсэн, “чулуу(гаар) шидэж байгаа юм шиг гутал(аар) шидэх” гэсэн санаа нь үүсмэл утга буюу “чулуу(гаар) шидэх” гэдгээс шалтгаацмал утга гэж болно.

Ийм аргаар үүссэн утга монгол хэлний үгсийн бүрэлдэхүүнд гэхэд л маш олон байна. Ийм үзэгдлийг их төлөв үгийн утга шилжих, утга салаалах үзэгдэлд хамруулан айчилж тодорхойлдог уламжлалтай ажээ. Харин ХХ зууны хоёрдугаар хагасаас хэлц нэгжийг Тайлалзүй (Герменевтика), Угсаатны хэлшинжлэл (Этнолингвистика), Сэтгэцийн Хэлшинжлэл (Психоллингвистика), Хэлний соёл судлал (Лингвокультурология) зэрэг хүмүүнлигийн ухаануудын уулзвар дээр шинжлэн судлахдаа хэлний тогтвортой нэгж бол шинэ ухагдахуун, түүний шинэ нэрлэлт үүсэх танин мэдэхүй, хийсвэрлэн сэтгэхүйн үйл ажиллагааны явц, үр дүн бөгөөд хэлц нэгжид түүний бүрэлдүүлбэрийн үндсэн утга буюу ямар нэг хувиар хадгалагдахын зэрэгцээ, тухайн хэлийг төрөлх хэлийг болгон харилцаж ирсэн үндэстэн угсаатны ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдал болон эртнээс нааш бүтээн цогцлоож, хойч үедээ өвлөн уламжлуулж ирсэн эдийн болон оюун билгийн соёлын онцлог нь тусч илэрсэн байдал гэж үздэг* болсноор өвөрмөц хэллэг, хэвшмэл хэллэг төдийгүй, дан үг ч гэсэн хэлцэжсэн утгатай байна гэж үздэг болжээ. Түүгээр ч үл барам, зарим тохиолдолд, бидний өмнө “чулуу-да-х” хэмээн жишээлсэн шиг, - дагавар бүтээвэр ч хэлцэжсэн утгатай байж болно. Бүтээврийн төвшинд хэлцэжсэн утга илрэх онцлогийг М.Базаррагчаа** олон арвин жишээгээр нотлон өгүүлсэн байдаг. Тэгвэл бидний өмнө

* Телия В.Н.-гийн өмнө ишилсэн энэ төрлийн бусад бүтээл, Ж. Баянсангийн Соёл, Хэл, Үндэстний сэтгэлгээ. УБ., 2002 номноос уг үзэл баримтлалын агуулга, харгалзах жишээг дэлгэрүүлэн үзэж болно.

** Базаррагчаа М. “Монгол хэл” УБ., 2000 болон түүний зохион хэвлүүлсэн дунд сургуулийн YI-XI ангийн сурах бичгийг үзнэ үү

жишээлсэн “ташуур-да-х” гэдэг үг ч гэсэн “ташуураар цохих” гэсэн шууд утгаасаа гадна “үгээр ташуурдах” гэх зэрэгт “бусдыг үг хэлээр мохоон дарангуйлах зорилгоор улам лавшруулан өгүүлэх” гэсэн шиг онцолмол утга (коннотаци) илрэх боломжтой.

Үгийн дотоод хэлбэрийн тухай судалгааны үр дүнг хэлц нэгжийг судлахад ашиглах болсноор хэлцийн бүрэлдэхүүнд орсон үгсийн дангаараа байхдаа илэрхийлдэг утга нь хэлцийн бүрэлдэхүүнд ямар шинжтэй болж байгааг тодорхойлох нэг арга болж өргөжсөн байна.

Ингэснээр өвөрмөц хэлц, хэвшмэл хэлц (хэллэг), бэсрэг хэлц буюу Телиягийнхээр Үгийн сангийн задлаг нийлц (аналитическая лексическая коллокация) гэх мэтээр тогтвортой хэллэгийн зүйлсийг ялган тодорхойлох бас нэг сэжүүр шижим бий болсон байна.

В.В.Виноградовын “фразеологическое сращение” гэдэг нь манай “өвөрмөц хэллэг” гэдэгтэй агуулгаараа дүйх ойлголт шиг байна. Учир нь тэрээр, тухайн хэлцийн ерөнхий утга нь түүний бүрэлдэхүүнд орсон үгсийн дангаараа байхдаа илэрхийлдэг утгаас хамааралгүй байх нь хэлц нэгжийн энэ хэлбэрийн гол онцлог гэж үзсэн бөгөөд харин “фразеологическое единство” гэдэг нь монгол хэлний “хэвшмэл хэллэг” гэдэгтэй агуулга бүтцээрээ дүйх үзэгдэл бололтой. Учир нь бүрэлдэхүүнд нь орсон үгсийн утга нь тухайн хэллэгийн утгыг үүсгэхэд шууд хамаатай байдаг үзэгдлийг үүнд хамаатуулсан байна. Оросын үгийн сан судлалч, хэлц судлалын бас нэг нэрт төлөөлөгч Н.М. Шанский бас үүнтэй адил саналтай байжээ.

Оросын хэлц судлалын “сонгодог үед” хамаарах нэг гол төлөөлөгч Б.А.Ларин: энгийн хэлмэли (речение) өвөрмөц хэллэг болох хамгийн гол нөхцөл бол зүйрлэх арга хэмээх утгазүйн нэг зүйлийн баяжилт бөгөөд энэ үзэгдлийн мөн чанар нь дүрслиг хэвшинж болтол нь тухайн утгыг өргөсгөн баяжуулах явдал юм (Ларин, 1977: 145-148)⁹.

Б.А. Ларины дэвшүүлсэн “Утга баяжих”, “Утга өргөсөх” гэдэг ойлголт нь нэг талаар “утга шилжих”, “үгийн дотоод хэлбэр”, шалтгаацимал үүтгэл (мотивировка) гэдэг ойлголттой агуулга нэгтэй, нөгөө талаар “онцолмол утга” (коннотация), эсвэл “хамсмал утга”, “соёлын тэмдэг”-ийн утга” (культурный знак), “үндэстэн-соёлын онцлогт хамаатай утга” (“культурно-национальная особенность”, “национально-культурная особенность”) зэрэг томъёолол, ухагдахуунтай бас холбоо хамаатай байна.

Үгийн “дотоод хэлбэр” гэдэг ойлголтыг 1910-1970-аад оны үед их төлөв Оросын* судлаачид хэрхэн авч үзсэнийг өмнө өгүүлснээр хязгаарлаж, одоо 1980-аад оноос хойшхи судлаачид уг асуудлыг хэрхэн үзэж тайлбарласныг товчоолон өгүүлье.

Энэ үеийн судлаачид ““үгэн дэх” “дотоод хэлбэр”-ийг “хэлц нэгж дэх “дотоод хэлбэр”-ээс ялгаж ойлгох учиртайг онцлон өгүүлж байснаараа өмнөх үеийн судлаачдын уг асуудлын талаарх үзэл баримтлалаас ялгаатай байна. Жишээлбэл, В.П. Жуков 1970-аад оны дундаас 1980-аад оны дунд хүртэл орос хэлний хэлц нэгжийн талаар судалгаа хийж хэд хэдэн бие даасан бүтээл, ганц сэдэвт зохиол, толь бичиг зохион хэвлүүлсэн бөгөөд түүний эдгээр бүтээлдээ гаргасан үр дүн, дэвшүүлсэн санал дүгнэлтийг тэр үеийн болон хожмын судлаачид олонтаа ишлэн баримталж ирсэн байна.

⁹ Ларин Б.А. Очерки по фразеологии (о систематизации и методах исследования фразеологических материалов) //Ларин Б.А. История русского языка и общее языкознание, М., 1977

* “дотоод хэлбэр (внутренняя форма)” гэдэг томъёолол бүхий Оросын эрдэмтдийн судалгааны хэрэглэгдэхүүн бидэнд илүүхэн олдсоныгоо тулгуур болгон ишлэн өгүүлж байгааг тэмдэглэе.

“Дотоод хэлбэр” гэдэг нь чөлөөт холбоо үг, түүний үндсэнд хийсвэрлэн бүтээсэн хэлцэжсэн илэрхийлэл хоёрын харилцан үйлдлээр бүтээсэн дүрийг хэлнэ” (Жуков. 1978:8)¹⁰. Иймд дотоод хэлбэр бол хэлц нэгжийн утгазүйн бүтцэд орж, түүний утгын хөгжлийг утган тодорхойлж байдаг зүйл гэжээ. Өөрөөр хэлбэл, дотоод хэлбэр нь зөвхөн хэлц нэгжийн хувьд л чухал учир холбогдолтой зүйл бөгөөд хэлц нэгж нь үгийн сангийн тухайн бүрэлдэхүүн бүхий чөлөөт холбоо үгэнд тохоогдон наалдаж, түүний дэвсгэр дээр утгазүйн болон зүйрлэлийн нөлөөтлийг үүсгэж байдаг ажээ.

Ийм учраас хэлц нэгжийн ерөнхий утга нь бүрэлдүүлэгч үгсийнх нь утгаас шууд мэдрэгдэхгүй, харин тайлалгүй өнгөрөх аргагүй дотоод дүрээр шалтгаацсан байдаг ажээ. Үүний үлгэр болгож В.П. Жуков “брать быка за рога”, үгчилбэл “бухыг эврээр нь барих” гэсэн хэллэг авчээ. Энэ хэллэг нь “Смело взяться за самое главное в трудное дело” (Ожегов. 1977:62)¹¹ (хэцүү бэрх ажлын хамгийн гол хэсгийг зориглон авах) гэсэн утгатай бөгөөд уг утга нь бүрэлдүүлэгч үгсийнх нь шууд утгаар биш, харин дотоод дүрийн тайлал болж шалтгаацсан хамааралтай байна гэжээ. Энэ хэллэгийн шууд утгын дагуу монголоор бодож үзвэл, их чадал тэнхээтэй, омголон догшин амьтныг эвэрдэж авсныг үзвэл “их хүч чадалтай, зоригтой хүн”-ий тухай өгүүлж байгаа юм болов уу? гэж санаанд бууж ч магадгүй, үгүй ч магадгүй. Гэтэл дотоод хэлбэр бол зөвхөн хэлц нэгжид л учир холбогдолтой байж, дотоод дүрээр утга нь тайлагддаг илэрхийлэл гэдэгтээ Жуков дараах жишээг авсан байна. “Выносить сор из избы” үгчилбэл тариачны модон байшингаас хог гадагшлуулах” гэдэг хэллэгийн утгыг “дотно хүмүүсийн хооронд гарсан хэрүүл маргаан, зөрчил зөрөлдөөнийг бусдад дэлгэх/задлах” гэсэн утгатай гэдгийг уг хэллэг үүсэхэд шууд хамаатай, оросын эртний уламжилсан аж төрөх арга ухаан, ёс заншлын утга учрыг ойлгохгүйгээр тайлах аргагүй бөгөөд хэрэв үгчилсэн утгаар нь өнгөцхөн бодвол “муу байшин гэрээсээ хог шороогоо гадагшлуулах” нь гэр орноо хир бургтаас цэвэрлэсэн, аминдаа арчаатай үйл явдлын тухай өгүүлж байгаа юм биш биз хэмээн тэс өөр өөрөөр ойлгож магадгүй ажээ.

Үүнтэй төслүүгээр “бух” оролцоноор нь бодож, монгол хэлний “бухын хамрыг мухар нударгаар” гэдэг хэллэгийг энэ байгаа шууд утгаар нь өнгөцхөн бодвол “нэгэн их чадал тэнхээтний тухай өгүүлэмж юм уу” гэвэл “мухар нударгаар байтугай сайтар үзүүлсэн эвэр шороор ч гэсэн бухын хамрыг цоолоход бэрхтэй учраас “бүтэшгүй тэнэг санаархалтан” хэмээн ёжилсон утгатайг нь зөрүүд гэжүүдийг “дөргүй бух шиг”, дуулгавартай номхоныг нь “дөрлүүлсэн бух шиг” хэмээн зүйрлэдэг бусад хэллэгүүдтэй нэг иж бүрдэл, багц болгон монгол хүн бухын хамрыг цоолж, дөрлөн ачлага уналгад хэрэглэж ирсэн хэдий боловч түүний хамрыг ийн цоолж, дөрлөн дуулгаваржуулах нь бас ч амаргүй байдгийг амьдралаараа мэдэрч ухаарсантай холбон үзэхгүй бол уг хэллэгийн “дотоод хэлбэр” буюу “дотоод дүр”-ээр зайлшгүй шалтгаацсан тайлагдах утга санааг таах аргагүй юм.

Ингэхлээр “дотоод хэлбэр” гэдэг ойлголтыг үг, чөлөөт холбоо үгэнд хамаатуулан ялгавартай ойлгох ёстой гэдэг нь чухал санаа байна.

Ямар нэгэн хэллэгт буй “дотоод хэлбэр” сарниж, мэдэгдэхгүй болохын цагт тэр хэллэг нийлмэл хам бүтэц буюу сращение болдог гэж В.П. Жуков үзжээ. Ингээд тэрээр “дотоод хэлбэр” бүхий хэлц нэгжээс гадна бүрэлдүүлбэрээс нь ерөнхий утгыг нь гаргаж болдог хэлц нэгж гэж байна гээд “хэн нэгэн хүнтэй дотно, нөхөрсөг харьцаатай байх”

¹⁰ Жуков В.П. Семантика фразеологических оборотов. М., 1978. Мөн түүний Русская фразеология. М., 1986

¹¹ Ожегов С.И. Словарь русского языка. М., 1977

гэсэн утга бүхий “на дружеской ноге” гэдэг хэллэгт утга санаагаараа “дотоод хэлбэр” байхгүй. Учир нь энэ хэллэг нь түүнтэй тэнцдэг (эквивалент болдог) чөлөөт холбоо үгтэй эсрэгцэж чадахгүй. Иймээс ерөнхий утга нь бүрэлдүүлбэрүүдийнхээ утгаас урган гарах боломжтой байдаг. Ийм төрлийн хэллэгт “найти общий язык, “отбивать хлеб” гэх мэт хэллэг ч хамаарах бөгөөд ийм төрлийн хэллэгүүд нь шалтгаацимал үүтгэл (мотивировка) утгатай болохоос биш “дотоод хэлбэр” байхгүй юм хэмээн жишээлэн өгүүлсэн байна.

Ингэхлээр хэлц нэгжийн утгыг тайлахад “дотоод хэлбэр”, “шалтгаацимал үүтгэл” хоёрыг ялгаж ойлгох учиртай гэсэн санааг В.П. Жуков онцлон тэмдэглэсэн байна.

Тэгвэл монгол хэлний “харамлах, харамч” гэсэн утга бүхий “гар татах” гэдэг хэллэг, “өглөгч, өглөг өгөх” гэсэн утга бүхий “гар сунгах” гэдэг хэллэгүүд “шалтгаацимал” утгатай болохоос биш “дотоод хэлбэр”-гүй байна гэж дүйлгэн ойлгож болох уу? гэсэн асуулт гармаар байдаг.

Нэгэнт хэлц нэгжийн утга нь бүрэлдүүлбэрүүдийнх нь утгаас шууд мэдэгдэх боломжгүй учраас уг хэлцийн үүсмэл утга буюу ерөнхий утга нь бодит байдлын тухайн юм үзэгдлийн тухай ямар нэг онцолмол нэрлэлт байдаг. Жишээлбэл, “харганы унгасаар эсгий хийх” гэдэг хэллэгийг шууд утгаар нь ургуулан бодоод байвал, логикийн үүднээс маш нямбай, ажилсаг хүн харгана бутанд сэмлэгдэн үлдсэн ноосыг уйгагүй түүж цуглуулсаар байгаад гэрийн дээвэр, туурганд хүрэлцэх эсгий хийдэггүй юм аа гэхэд оймс, тохонны эсгийд хүрэлцэхүйц унгас ноос түүгээд авахыг үгүйсгэх аргагүй. Гэвч энэ хэллэгийн утга нь харин ч үүний эсрэгээр буюу “огт бүтэхгүй зүйлээр оролдож цаг заваа дэмий үрэх” гэсэн санаа байдаг нь саяхи тэмдэглэсэн “тухайн юм үзэгдлийн тухай онцолмол нэрлэлт” байдгийг гэрчлэх жишээ юм. Ингэж үүсдэг онцолмол нэрлэлт нь тухайн хэллэгийн “дотоод хэлбэр” гэж томъёоллын мөн чанарыг таних шижим болно. Ийм учраас харилцааны тодорхой орчин нөхцөлд хэрэглэгдэж буй дүрслиг хэлцийн тухайд эхлээд “онцолмол утга” нь шууд мэдрэгдэх боловч ихэнх хэлцийн хувьд “дотоод хэлбэр” нь уг хэлцийг ойлгоход их дөхөмтэй болгодог ажээ.

Ингэж үзвэл, хэлц нэгжийн утга санааны бүтцэд багтаж буй “дотоод хэлбэр” нь хэлцийн утгыг ялгах ч бүрэлдүүлбэр биш, нэгтгэх ч бүрэлдүүлбэр биш ажээ. Харин дан үгийн тухайд “дотоод хэлбэр” нь утгыг эсвэл ялгах, үгүй бол нэгтгэх үүрэгтэй бүрэлдүүлбэр байж болно.

Өөрөөр хэлбэл, “тээрэмдэх”, “талхлах ≈ талхдах” гэсэн дан үгийг тус бүр шилжсэн утгаар хэрэглэж байна гэж үзвэл энэхүү “дотоод хэлбэр”-ийн утга ялгаруулах, эсвэл нэгтгэх үүрэг нь ямар байгааг ажиглаж болно. Тодруулбал, “Тэр хүн их л өлсөж цангасан амьтан бололтой. Өмнөө тавьсан шүүсийг тээрэмдэж өгөөд гарлаа” гэхэд “идээ шүүснээс зөвхөн яс үсхэн, сэг зэмхэн үлдэж, бусды нь идээд дуусгах” гэсэн утга санаа илэрхийлнэ. Гэтэл энэ “тээрэмдэх” гэдгийн оронд “талхлах” гэвэл идэж дууссан биш, харин тарааж цацсан ч юм уу, аяга тавгий нь хагалж хэмхлэсэн юм болов уу гэсэн өөр утга илэрхийлж болно. Тэгвэл “тээрэмдэх” гэвэл шууд утгаараа, гурил будаа мэтийн хатуу бүхэл зүйлийг тээрмээр бутлах, бяцлах, нунтаглах, бас талхлах ч гэсэн санаатай бол “талхлах ≈ талхдах” гэхэд бас л ямар нэг бүхэл бүтэн зүйлийг нунтаглах, бутчих, хэмхчих, хамхчих, үрэн таран болгох, үртэс, үйрмэг болгох хэмээсэн утгатай болно.

Ингээд “тээрэмдэх” нь “жигд бутлах, няцлах” гэсэн бодит утгаас үүтгэлтэй бол “талхлах ≈ талхдах” нь тус бүр өөр өөр хэсэг боловч нэг иж бүрдэл болсон зүйлийг эмх

цэгций нь алдуулах, бусниулах, тараах сандаачих энэ завсар бас эвдэлж хэмхчих” гэсэн утгаас дам хийсвэрлэн утга шилжүүлж хэрэглэснийг мэдэж болно. Ингэхлээр “бүхэл бүтэн зүйлийг бутлах хагалах, хамхлах, хэмхлэх, бутлах няцлах” мэтийн утга нь уг хоёр үгийн шилжмэл утгын нийтлэг (integral) бүрэлдүүлбэр бөгөөд харин “тээрэмдэх” нь бүхэл бүтэн юмыг “үйрмэг, үртэс” болгох нь жигд буталж няцлах”, “талхлах ≈ талхдах” гэвэл “иж бүрдэл (нэгэн бүхэл) зүйлийг бусниулах, эмх цэгцийг нь алдуулах” гэсэн утга нь эдгээр ойролцоо утгатай үгээс үүссэн, бас ойролцоо утгатай шилжмэл утгыг ялгах (differential) бүрэлдүүлбэр гэж ойлгож болно.

Үүнээс үзвэл, хэлц нэгжийн “дотоод хэлбэр” бол тухайн хэлцийн онцолмол (actual) утгыг дагалдсан биеэ даасан утга юм. Энэ утгыг зарим судлаач “гарвалзүй буюу этимолог утга хэмээн нэрлэсэн ч бий. Гэхдээ энд хэрэглэж байгаа гаралзүй (этимолог) гэдэг нь тухайн чөлөөт холбоо үгсийнхээ утгаас гарвал сурвалж нэгтэй буюу түүнээс үүтгэгдсэн утга гэсэн санаагаар ийн томъёолсон хэмээн ойлгож байна. Учир нь хэлц нэгжийн “дотоод хэлбэр” буюу энэхүү “гарвалзүйн” утга нь түүний илэрхийлэл, дэвсгэр болсон чөлөөт холбоо үгтэй харилцан шалтгаалалцах хамааралтай улмаар адилтган зүйрлэх (metaphorisation) аргаар дамлан хийсвэрлэсэн, шинэ утга юм. Дээрх өгүүлсэн зүйлийг хурааж хэлбэл, хэлцийн утга гэдэг бол чөлөөт холбоо үгийн утгыг зүйрчилэх (metaphorisation) аргаар үүссэн утга юм хэмээн тодорхойлж болно.

Харин хэлцийн утгыг ийн тодорхойлохдоо үндсэн утга, шилжмэл утга хоёрыг ямар шинж холбож байгааг нягтлан үзэх хэрэгтэй болж байна. Жишээлбэл, ажил (ялангуяа хар бор ажил) хийх дургүй, залхуу зан байдлыг тодорхойлсон “цагаан гартан” гэдэг адилтгал, сайхан сэтгэлтэй хүнийг хэлсэн “цагаан сэтгэлтэн” гэдэг адилтгалд орсон “цагаан” гэдэг үгээр тэмдэглэн илэрхийлсэн зүйлийн ямар шинж нь уг хэлцийн үндсэн ба шилжсэн утгыг холбох шижим болж байна вэ? гэх мэтийн асуудал зайлшгүй гарч ирнэ. Тэгвэл ер нь “цагаан” өнгө бол “ариун, гэгээн, бас саад тотгоргүй, шулуун шударга, ил тод”-ын бэлгэдлийг илэрхийлдэг. Ийм учраас “цагаан гартан” гэхлээр “ариун” гэсэн утгатай бол уг адилтгал “буянтай, өглөгч, ач тустай” зан чанарыг илэрхийлсэн үү? гэвэл үнэндээ тийм юм. Гэвч егөөдөх найруулгын ёсоор эсрэг талаас нь өгүүлж буй учраас энэ “ариун” хэмээх үндсэн утга нь “залхуу” хэмээх шилжмэл утгын нөлөөтэй толинд туссан дүрс мэтээр “гажиж” холбирсон шинж гэж болно. Чухам энэ шинж нь “цагаан сэтгэлтэн” гэдэг адилтгалд илэрсэн “сайхан, ач буянтай, хайр татам” гэх мэт утгатай холбогдох шижим нь болж байна. Тэгвэл “цагаан зам”, “цагаан газар” гэхлээр “саад бартаагүй, тийм учраас явах орчиход амар хялбар” гэсэн утгаараа “сайхан зам, сайхан газар, сайн зам/газар, гэгээн (ил тод) газар/зам гэсэн утгас нь “цагаан” хэмээх нэрээр тодотгуулан холбосон холбоо үгээс үүссэн шилжмэл утгын хоорондох дифференциал ба интеграл шинжийг тодорхойлох арга болж байна. Гэтэл дуу авиаг алс хол дамжуулан хүргэхээр зохион бүтээсэн нэгэн төхөөрөмжийг 1960-аад оны үед “цагаан хоолой” хэмээн нэрлэжээ. Тэгвэл энд орсон “цагаан” нь өнгөний нэрийнхээ үүргээр орсон болохоос биш өмнөх жишээнүүдэд орсон шиг шилжмэл утга байхгүй. Харин “хоолой” нь хүний дуу авианы үүтгэл болдог “хоолой”-ны үүргээр нь адилсуулсан, шилжмэл утгатай хэрэглэгдсэн байна.

Гэвч бие цогц судлалын монгол уламжлалт нэр томъёо болсон “цагаан хоолой”, “улаан хоолой” гэсэн хоёр нэр бий. Үүний “цагаан хоолой” нь мөгөөрсөн хоолой буюу амьсгал татах/гаргах, дуу үүсгэх хийн түрлэгийн зам хоолой”, нөгөөх нь хоол унд залгих, ходоод гэдсэн доторх зүйл буцаж гарах (улаан) махан хоолойн нэр ажээ. Тэгвэл дуу авиа үүсгэх хийн түрлэгийн орон замыг илэрхийлэх энэ “мөгөөрсөн хоолой” буюу

“цагаан хоолой” нь дуу авиаг алсад дамжуулах цахилгаан соронзон долгионы үйлчлэл, үелзлийн аргыг ашиглаж, цагаан төмрөөр хийсэн “цагаан хоолой” хоёр үндсэн ба шилжмэл утга үүсэх шалтгаан, үрийн харилцан хамааралтай болсон байж болох юм.

Гэвч энэ хоёр зүйл “цагаан хоолой”-ны аль алинд “цагаан” гэдэг нэрийн “өнгө заасан” үүрэг нь шууд утгын илэрхийлэл болсон байна. Бүр нарийвчилж хэлбэл, шууд утгаас шилжмэл утга үүсэх үйл явцын дундах агшины үзэгдлийг таньж мэдэхэд учир холбогдолтой байна гэж хэлж болох юм. Өөрөөр хэлбэл, шууд утгаас дамнасан “хагас шилжмэл” утга буюу завсрын утга гэмээр үзэгдэл болж байна.

Сэтгэцийн хэлшинжлэлийн үүднээс хэлэхүйн үйл ажиллагааг судлахдаа “дотоод хэлэхүй” нь дотроо таван үе шаттай байж болохыг А.А. Леонтьев (1969, 1991)¹² тодорхойлсон нь хүний сэрэл мэдрэхүйд шууд эс хүртэгдэх өгүүлэх/сонсох, хэлэхүйн үйл ажиллагааны сэтгэцийн оньсыг гагцхүү туршин судлах (эсперименталин) арга, хийсвэрлэн сэтгэх аргыг хослуулан хэрэглэснээр уг үзэгдлийн дотоод мөнчанарыг нээх боломжтой байдаг шиг чөлөөт холбоо үг, түүнээс “дотоод хэлбэр”-ээр дамжин “үүсмэл утга (зүйрлэмэл утга) буюу шилжмэл утга, улмаар хэлц нэгж хэмээх, тодорхойлмол харьцаа (синтагматик)-ны нэг зүйл үүсч байгааг модуль маягаар ойлгон хэлэлцэж болох юм.

Хэлц нэгжийн утгазүйн судлалд үүсдэг бас нэг ээдрээтэй асуудал бол хэлцийн олон утга, эсвэл, ойролцоо утгатай хэлцүүд, үгүй бол нэг хэлцийн олон хувилбарыг ялгаж тодорхойлох асуудал юм. Энэ нь үгийн олон утга, ойролцоо утгатай үг, нэг үгийн олон хувилбар хэлбэр гэдэгтэй нэг арга зарчмаар авч үзэх асуудал боловч төвшний хувьд эхнийх нь сүүлчийнхээсээ дээд төвшний үзэгдэл баримт юм. Харин хэлц нэгжийн олон утга, ойролцоо утга, эсвэл нэг хэлцийн хувилбарыг ялган тодорхойлох нь үгийнхээс нэлээд ярвигтай байдаг.

Монгол хэлний

1. Үхрийн эвэр дээр будаа тогтоох
2. Нохойн нуруунд тогтсон цас
3. Усанд өрөм тогтоох гэсэн хэлцүүд ойролцоо утгатай юу, үгүй юу гэдэг нэг асуудал гарна. Нөгөөтээгүүр
4. Харганы унгасаар эсгий хийх
5. Үхсэн эмгэнээс унгас эрэх
6. Эр үхрийн сүүгээр элгэн тараг бүрэх
7. Үнсээр чөдөр зангидах гэдэг хэллэгүүдтэй дээрх (1, 2, 3) хэллэг ойролцоо утгатай болох уу? гэсэн бас нэг асуулт гарч болно.

Үүнийг тогтоон тодорхойлохын тулд “дотоод хэлбэр” гэдэг шүүлтүүрийг хэрэглэж үзвэл ямар үр дүнд хүрч болохыг ажиглая. Тэгвэл (1,2) нь “түр зуурынх” гэсэн утгаараа, (3,4,5,6,7) нь “бүтэшгүй, биелэшгүй” гэсэн утгаараа тус тус нэгдмэл утга санаа илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, “дотоод хэлбэр”-ийн үүднээс дээрх хоёр зүйлийн утга нь тэдгээр бүлэг хэллэгийн утгын, бидний өмнө тэмдэглэсэн, нэгтгэх (нийтлэг) (интеграл) шинж нь болж байна.

Гэвч эдгээр хэллэгийн алинд ч гэсэн “худал хуурмаг, үзэгдэл төдий” гэсэн бас нэг санаа агуулагдаж байгааг анзаарахгүй өнгөрөх аргагүй юм.

¹² Леонтьев А.А. Язык, речь, речевая деятельность. М. 1969, Леонтьев А.А. Основы психолингвистики. М., 1997, Мөн Человеческий фактор в языке: Языковые механизмы экспрессивности М., 1991 бүтээлүүдээс уг асуудлыг дэлгэрүүлэн үзэж болно.

Харин гарал үүслийн хувьд (6,7) нь ардын үлгэр домгийн өгүүлэмжээс үүдэлтэй бол, бусад нь монгол үндэстний аж төрөх ёс, амьдрах арга ухаан, мэдлэг туршлагаас үүдэлтэй байгааг бас ажиглаж болно.

Гэтэл 8. Санаа нь эзнээ голохгүй

Сархинаг нь баасаа голохгүй

9. Дур нь эзнээ голохгүй

Дунд чөмөг нь сүүжээ голохгүй

10. Эзэн нь юмаа голохгүй

Ирэг нь сүүлээ голохгүй гэсэн хэллэгүүд ойролцоо утгатай өөр өөр хэллэгт хамаарах уу? эсвэл нэг хэллэгийн олон хувилбар болох уу гэсэн асуулт гарч болно.

Тэгвэл “өөрийн юм өөртөө зөв” гэсэн нэг нийтлэг утгатай байна. Өөрөөр хэлбэл, голж шилж, гоочилж өөчилж болдоггүй зүйлийн тухай нэг өгүүлэмжтэй байна гэж хэлсэн ч болохоор юм.

Гэтэл (8) нь санаа, сархинаг хоёр, (9) нь дур, эзэн (хүн) хоёр, (10) нь эзэн (хүн), ирэг хоёрт байх “эс үгүйсгэгдэх мөнчанар”-ын тухай зүйрлэн өгүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, “ямар нэг юм үүтгэл, орчиндоо зайлшгүй зохирол харьцаа хамааралтай байхаас өөрөөр орших аргагүй” гэсэн санааг хоёр бодгалиар жишин өгүүлсэн байна.

Тэгвэл иймэрхүү бүтэц агуулгатай хэллэгүүд нь монгол ардын аман зохиолын нэг өвөрмөц зүйл болох “ертөнцийн гурав”-тай бүтэц-агуулгаараа тохирох учир байна уу? гэсэн бас нэг асуулт гарч болох юм. Тэгвэл дээрх хэллэгүүд нь:

Жавартай тэнгэрийн хаяа улаан

Жаргалтай хатны хацар улаан

Жалганд ургасан сухай улаан хэмээх “ертөнцийн гурван улаан”-ы тухай гэдэг шиг “ертөнцийн гурван гологдошгүй”-н тухай хэмээн хэлэлцэж болох уу? гэсэн үг юм.

Тэгвэл “ертөнцийн гурав”-д шалтгаан, үр хоёрын тус бүрийнх нь үүтгэл буюу зүйл нь ил тодорхой, тэдгээрийн дотоод харьцаа хамаарал нь далд дам шинжтэй байх шиг байна. Өөрөөр хэлбэл, тэнгэрийн хаяа улайран байх (үр) нь жавар салхинаас шалтгаалалтай, хатны хацар улайран байх (үр) нь бие сэтгэлийн дарамт, зовлон үгүй буюу аз жаргалтай байдлаас үүтгэл шалтгаалалтай, сухай улаан байх (үр) нь нөмөр нөөлөг, ус чийгтэй газар ургаснаас үүтгэл шалтгаалалтай нь мэдрэгдэж, “юм болгон цаанаасаа ямар нэг зайлшгүй зохирол, бололцоотой байна” гэсэн санаа нь далдхан илэрсэн гэж хэлж болно. Гэтэл (8, 9, 10) зүйрлэсэн хэллэгт илэрхийлэх хэмээн “зорьсон санаа” нь ил, харин энэхүү илэрхийлэлд хүрсэн явцын утга санаа нь далдлагдсан байдалтай байх шиг байна.

Ер нь зүйрлэсэн хэллэг ч тэр, ертөнцийн гурав ч тэр, өвөрмөц хэллэг ч тэр илэрхийлж байгаа утга санааг тайлахын тулд тухайн хэллэгт өгүүлж байгаа юм, үйлийн тухай мэдлэг чухал учир холбогдолтой байна.

Ийм учраас “санаа нь тэнгэрт, салтаа нь цасанд” гэх буюу “саваагүй нохой саранд хуцна” гэсэн хэллэгүүд нь харин дээрх хэллэгүүдийн утгын тайлал болох мэт юм. Өөрөөр хэлбэл, ойролцоо утгатай хэллэгүүдийн утгын тайлал болохдоо өөрөө зүйрлэсэн хэллэг байдаг энэ үзэгдлийг Мета хэлц гэж томъёолж болох юм. Энэ бол

хэлээр үүтгэн цогцлоох сэтгэхүйн* үйл ажиллагааны дээд эрэмбийн хийсвэрлэлд хамаатай текстийг хураах, үүний эсрэгээр задалж дэлгэрүүлэх үйлдлийн нэг хэв маяг юм. Тэгвэл:

11. Жалга жалгын нохой хуцах өөр

12. Лам ламын уншлага өөр

13. Гүзээ гүзээний булан өөр

14. Бөө бөөгийн дуудлага өөр

Бөжин туулайн шогших өөр гэх мэт хэллэг ч дээр жишээлсэнтэй хэлбэр бүтэц, утга агуулгаараа нэг хэв маягт хамаарна.

Гэтэл:

15. Хүний хүү хүрэн бөөртэй

Өөрийн хүү өөхөн бөөртэй

16. Хүний морь унасан хүний нуруу янгинана

Хүний дээл өмссөн хүний мөр өвдөнө.

17. Хүний гуяны мах хүнд наалдахгүй

18. Хүний юм хүсэвч цаашаа

Өөрийн юм өшивч наашаа

19. Өмхий айраг эзэндээ амттай

20. Хүний нохой идэхээр

Өөрийн нохой ид

21. Өөрийн юм өөртөө зөв

Өрөөл даавуу биедээ зөв зэрэг хэллэгүүд нь ойролцоо утгатай байна.

Тэгвэл (8, 9, 10); (11, 12, 13, 14) хэллэгүүд тус бүрдээ зүйлчилсэн хэв маяг бүхий ойролцоо утгатай бол (15-21) хэллэг нь тодорхойлсон* хэв маяг бүхий ойролцоо утгатай гэж ялган үзэж болно.

Өөрөөр хэлбэл, ойролцоо утгатай хэлцүүд нь багцалмал мэдлэг буюу концепт (concept) –ийг үүсгэх шалтгаан болох буюу концептийн бүрэлдүүлбэр болдог бол зүйлчилсэн хэллэгүүд нь концептийн нэгэн бүрэлдэхүүний бүрэлдүүлбэрүүдийг солин нэрлэх шинжтэй байдгаараа нэг хэлцийн хувилбар (Variation)-ын шинжтэй гэж ялган үзэж болно. Тухайлбал, (11,12,13,14) хэв маяг бүхий хэллэгүүд “нэг төрлийн зүйлс нь юугаараа бие биенээсээ өөр өөр байдаг вэ? гэсэн асуултын хариу болж:

- жалга жалгын нохой хуцах өөр

- лам ламын уншлага өөр

- гүзээ гүзээний булан өөр

- хүн хүний бодол өөр

- бөө бөөгийн дуудлага өөр

- Бөжин туулайн шогших өөр.... гэх мэт бүтэц агуулгатай байна.

Үүнчилэн – нарийндаа хатах

- (долоон) хорголоо тоолох

- гарын алга дээш харуулж үзээгүй

- гаднах нь гэртээ, гэрдэх нь гэдсэндээ ороогүй

* Энэ тухай Б.А. Серебренников. Роль человеческого фактора в языке. Язык и мышление. М., 1988 стр 108-210, 210-213; Ж. Баянсан Соёл, Хэл, Үндэстний сэтгэлгээ. Уб, 2002 бүтээлүүдээс дэлгэрүүлэн үзнэ үү.

* “Зүйлчилсэн” гэсэн нь “парадигматика”, “тодорхойлсон” гэсэн нь “синтагматика” гэдэг ойлголтыг илэрхийлэх нэршил болгон хэрэглэснийг тэмдэглэе.

- юм үзээгүй
- хужирхай нь тэнийгээгүй
- чанга гартай

- лонхонд унгаад нохойд зайлж өгөх зэрэг хэллэгүүд нь “харамч”¹³ хэмээх концепцийн агуулга болно. Нөгөөтээгүүр эдгээр хэллэгийг “харамч” гэсэн утгыг илэрхийлэх ойролцоо утгатай хэллэг гэж бас үзэж болно. Энэ нь зүйлчилсэн утгатай хэллэгээс ялгаатай байгааг ажиглахад төвөггүй байна.

Гэтэл “баруун гарын хүн” гэдэг хэллэг нь өгүүлэх этгээд тухайн хүнд талтай, эсэхээс хамаараад “нөхөр, эсвэл дайсан” гэсэн эерэг, сөрөг үнэлэмжийн утгатай байж болдог нь нэг хэллэг харилцааны тодорхой орчин нөхцөлд хэрэглэгдэх хэрэгцээнээсээ үүдээд өөр өөр утга илэрхийлэх боломжтой байхыг хэллэгийн олон утга ч юм уу, салаалсан утга гэж хэлж болно.

Өөрөөр хэлбэл, тодорхой орчин нөхцөлд, тодорхой хам сэдвийн хүрээнд тухайн хэллэгийг зориуд утга тонгоруулах буюу ёжлох зэрэг өнгө аясаар хэрэглэх нь хэллэг утга салаалах үндэс шалтгаан болж болно.

Гэтэл “тэмцээн 2:1-ийн харьцаатай дууслаа” гэсэн өгүүлэмжийн нь (хэлц биш) хожсон багийн тухайд “ялсан”-ы утгатай, хожигдсон багийнханд “ялагдсан”-ы утгатай¹⁴ байж болдогийн өөр нэг үзэгдэл хэлцийн төвшинд илэрч байгаа хэрэг юм.

Харин “Давааны цаанаас тархидах ≈ Давааны араас тархидах” хоёр нь нэг хэллэгийн хоёр хувилбар болно. Өөрөөр хэлбэл, “дотоод хэлбэр” нь ижил байна гэсэн үг.

РЕЗЮМА

В этой статье рассматривается функции “внутренней формы” фразеологических единиц монгольского языка.

Различие мотивировки и внутренней формы фразеологических единиц является одним из ключевых понятий парадигматических и синтагматических корреляций устойчивых единиц языка.

В этом отношении другим важным свойством для семантической классификации фразеологических единиц являются их дифференциальные и интегральные признаки.

В рамках этого исследования были затронуты некоторые методологические аспекты тематической классификации фразеологических единиц монгольского языка.

¹³ Баянсан Ж. Соёл, Хэл, Үндэстний сэтгэлгээ. Уб., 2002

¹⁴ Общее языкознание. Минск., 1983